

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын код: ЗАА-2018/16/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189 Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586 Цахим хаяг: Khash_aud@yaoo.com

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 70463783, 99014227 98644227 Цахим хаяг: b_dagvaa@yahoo.com

Шилүүстэй сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.12	Шилэн дансны мэдээлэл	11
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	Error! Bookmark not defined.
3.1	<u>«management_zurchil1»</u>	Error! Bookmark not defined.
3.2	<u>«management_zurchil2»</u>	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл..	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг скайннердаж оруулах



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-3612

2018.03.13 № 211
танай _____ -ны № _____ -т

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.АЛТАНЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3 –д заасны дагуу Шилүүстэй сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шилүүстэй сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шилүүстэй сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.УЛАМБАЯР

STB-2017

152 594

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Тайланг Шилүүстэй сумын Засаг дарга Д.Алтанжаргалд -нд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Шилүүстэй сумын Засаг дарга-ын 2017.12.31* оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шилүүстэй сумын Засаг дарга-ын 2017.12.31 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг *2018.03.05* - наас *2018.03.12* – ны хооронд хийж, аудитын тайланг *2018.03.14* - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Төрийн аудитын газрын Ахлах аудитор Б.Дагвасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Шилүүстэй сумын Засаг дарга-ын 2017.12.31 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018.03.05 - нд төрийн аудитын байгууллагад 2018.03.07-ны өдрийн 1/101–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шилүүстэй сумын Засаг дарга “Иргэдийн хууль ёсны ашиг сонирхолыг эрхэмлэж төрийн үйлчилгээг хүртээмжэй тэгш шударга үр нөлөөтэй хүргэх явдал юмаа” эрхэм зорилгын дор Завхан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч-ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Шилүүстэй сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ.

Тайлант хугацаанд Шилүүстэй сумын Засаг дарга “Сумын засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн хүсэлт санал гомдлыг хууль зүйн дагуу барагдуулж хариу өгөх” дэвшүүлэн ажиллажээ.

Шилүүстэй сумын Засаг дарга-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Шилүүстэй сумын Засаг дарга-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
-

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны бодлогын баримт бичгийг боловсруулах

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Аудитын явцад судалсан дотоод хяналт, түүний үнэлгээний үндэслэл, тайлбарыг авч үзэхэд ерөнхийдөө хангалттайгаас гадна аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудит, дотоод хяналт шинжилгээний хэлтсүүдээс төлөвлөгөөт аудитуудыг хийсэн байна

Шилүүстэй сумын Засаг дарга-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 гэж үзлээ.

Шилүүстэй сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Э” тайлан” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Шилүүстэй сумын Засаг дарга –ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 11 асуудал эрсдэл өндөр, эрсдэл дунд, эрсдэл бага асуудал гараагүй гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 33 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 11 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь -тай холбоотой юм.

Шилүүстэй сумын Засаг дарга –ийн/ын 2017.12.31 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1707.2 сая төгрөг бөгөөд түүний 1хувь 17.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Эрсдэл багатай гэж үзэн материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь –тай холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 12 эрсдэлтэй асуудалд 12 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	77665.7	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	77665.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Төлбөрийн адт тогтоох алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

СХС-ийн хугацаа хэтрэсэн 77665.7 мянган төгрөгийг барагдуулахаар албан шаардлага өгөө

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зөрчилтэй асуудал байхгүй

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Асуудал байхгүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сум хөгжүүлэх сангийн зээл 77665.7 мянган төгрөгөөр эргэн төлөлтийн хугацаа хэтрэсэн зээлийг барагдуулах

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шилүүстэй сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1142.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 28.1 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгө ө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1264800800	1234956348 .5	2.35961674755424 16%	- 2.98444515 E7
1.1	Урсгал зардал	1142750800	1128974498 .5	1.20553855661269 44%	- 1.37763015 E7
1.2	Хөрөнгийн зардал	28130000	21301950	24.2731958762886 53%	- -6828050.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	93920000	84679900	9.83826660988074 8%	- -9240100.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл 84 хувь байгаа нь Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэл 1234.9 мянган төгрөг байгаа нь батлагдсан төлөвлөгөөнөөс 29.8 сая төгрөгөөр хэмнэсэн дүнтэй байгаа нь төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл, сум хөгжүүлэх сангийн орлого, орон нутгийн давсан орлого нөлөөлж байна холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 67.4 сая төгрөг байгаа нь төсөвт байгууллагуудаас өөрийн орлого ороогүй бөгөөд харин сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт, орон нутгийн давсан орлого орлого давж биелэхэд нөлөөлж байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 28.7 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 23.1 сая, хөрөнгийн зардалд 5.7 сая төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Шилүүстэй сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 12 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 12 горим сорил хэрэгжүүлэв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017.12.31 оны жилийн эцсийн байдлаар өмнөх зөвлөмжийн биелэлтийн хувь 31.7 хувь байгаа нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байна хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг *Шилүүстэй сумын Засаг дарга* 2017.10.24-ны өдрийн 1/238 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Шилүүстэй сумын Засаг дарга*-ын 2017.12.31 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шилүүстэй сумын Засаг дарга-ын 2017.12.31 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.15 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.16 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.17 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.18 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Менежментийн захидлыг бичсэн:

Ахлах аудитор

Б.Дагвасүрэн

Хянасан:

Аудитын менежер

Г.Хашцэцэг

Дарга, тэргүүлэх аудитор

Л.Уламбаяр

